# УДИРТГАЛ ЁСЛОЛ

Залбирал наманчлалын їйлээр бид Сургаал болон Ариун Зан Їйлэнд ирдэг Христтэй уулзахад бэлтгэдэг. Бид итгэлээр тїїнтэй болон бие биентэйгээ нэгдсэн нэгдлээ дурсан тэмдэглэхээр залбирлын нэгдэл болон цуглардаг.

## ЭХЛЭЛИЙН ДУУ

Христийн хїмїїс болон цугларсан бид єєрсдийн дунд байгаа Бурханд магтаалийн дуу хоолойгоо єргєснєєр ёслолыг эхэлдэг бєгєєд энэ дуу нь єнєєдрийн Мєргєлийн эхлэл тєдийгїй бидний нэгдлийг бэхжїїлдэг юм.

## ЗАГАЛМАЙЛАЛ БОЛОН МЭНДЧИЛГЭЭ

Эхлэлийн дууны дараа ёслолын удирдагч болон сїсэгтнїїд зогссон хэвээр ёслолын удирдагчын хэлснээр загалмайлна:

Аав, Хїї, Ариун Сїнсний нэрээр.

Сїсэгтнїїд хариулна:

**Амэн.**

Ёслолын удирдагч Их Эзэний нэрээр бидэнтэй мэндчилнэ. Бид Бурхан болон хїмїїс, ёслолын удирдагчтай нэгэн нэгдэлтэйгээ харуулж нэгэн зэрэг тїїний мэндчилгээнд хариулна.

**А** Бидний Их Эзэн Есїс Христийн ивээл,
Бурханы хайр, Ариун Сїнсний нєхєрлєл, та бїхэнд байх болтугай.

Сїсэгтнїїд хариулна:

**Тантай ч бас хамт байх болтугай.**

**Б** Бидний Эцэг Бурханы ивээл болон
амар амгалан мєн Их Эзэн Есїс Христ
та бїхэнд байх болтугай.

Сїсэгтнїїд хариулна;

**Бидний Их Эзэн Есїс Христийн Эцэг Бурхан ерєєлтэй.**

Эсвэл:

**Танд ч бас байх болтугай.**

**В** Их Эзэн та нартай хамт байх болтугай.

(“Их Эзэн та нартай хамт байх бол- тугай” ерєєлийн оронд хамба лам “Амар амгалан та нартай хамт байх болтугай” хэмээн хэлж болно.)

Сїсэгтнїїд:

**Тантай ч бас хамт байх болтугай.**

## НАМАНЧЛАХ ЁСЛОЛ

Бурханы їгийг сонсохоосоо ємнє бид нїглээ хїлцэнгїйгээр хїлээн зєвшєєрч, єршєєл эрэн тїїний уучлалыг хїлээн авдаг. Ёслолын удирдагч дараах їгийг хэрэглэнэ:

**А.** Христийн хайрын нууцыг тэм- дэглэхэд бид бэлтгэж буй учир,
бїгдээрээ алдаа дутагдлаа хїлээн зєвшєєрч, Их Эзэнээс єршєєл болон хїч чадал гуйя.

**Б.** Бурханы гэр бїл болон цугларцгааж, итгэлтэйгээр Ааваас єршєєлийг гуйя.
Учир нь Тэр энэрэл нигїїслээр дїїрэн билээ.

**В.** Ахан дїїс минь, талархалын ёслолын нууцыг тэмдэглэхэд єєрсдийгєє бэлтгэж, нїгэл хилэнцээ эргэн санацгаая.

Хэсэг мєч чимээгїй эргэцїїлнэ. Їїний дараа доорхи гурван тєрлийн залбирлаас сонгон хэлнэ:

**А.** Бїгд:

**Агуу хїчирхэг Бурхан бас**
**ахан дїїс та нартаа, єєрийн**
**буруугаас бодлоороо, їгээрээ,**
**хийсэн болон хийгээгїй бїхнээрээ нїгэл їйлдэж байснаа би хїлээе.**
**Мєнхєд Цэвэр Ариун Мариа,**
**бїх гэгээн хїмїїс, тэнгэрийн элчїїд,**
**бас ах дїї та нараасаа,**
**бидний Бурхан Их Эзэнд миний тєлєє залбирахыг гуйя.**

Ёслолын удирдагч єршєєлийн їгийг хэлнэ:

Агуу хїчирхэг Бурхан биднийг єршєєж, нїглийг маань хэлтрїїлэн,
мєнхийн амьдралд аваачих болтугай.

Сїсэгтнїїд:

**Амэн.**

**Б.** Ёслолын удирдагч:

Их Эзэн, бид Таны эсрэг нїгэл їйлдсэн: Их Эзэн єршєєгєєрэй.

Сїсэгтнїїд:

**Их Эзэн єршєєгєєрэй.**

Ёслолын удирдагч:

Их Эзэн єршєєл хайраа бидэнд їзїїлээч.

Сїсэгтнїїд:

**Бас бидэнд авралаа хайр-лаач.**

Ёслолын удирдагч єршєєлийн їгийг хэлнэ:

Агуу хїчирхэг Бурхан биднийг єршєєж, нїглийг маань хэлтрїїлэн мєнхийн амьдралд аваачих болтугай.

Сїсэгтнїїд:

**Амэн.**

**В.** Ёслолын удирдагч:

Та биднийг нїглээс аврахын тулд илгээгдсэн:
Их Эзэн єршєєгєєрэй.

Сїсэгтнїїд:

**Их Эзэн єршєєгєєрэй.**

Ёслолын удирдагч:

Та нїгэлтнїїдийг дуудахаар ирсэн:
Христ єршєєгєєрэй.

Сїсэгтнїїд:

**Христ єршєєгєєрэй.**

Ёслолын удирдагч:

Та Эцэгийн баруун гар талд биднийг ємгєєлдєг:
Их Эзэн єршєєгєєрэй.

Сїсэгтнїїд:

**Их Эзэн єршєєгєєрэй.**

Ёслолын удирдагч мєргєлийн їгийг хэлнэ:

Агуу хїчирхэг Бурхан биднийг єршєєж, нїглийг маань хэлтрїїлэн мєнхийн амьдралд аваачих болтугай.

Сїсэгтнїїд:
**Амэн.**

## КИРИЯ

Наманчлах їйлд хэрэглэдэг "Их Эзэн єршєєгєєрэй" мєргєлийн їгийг хэлнэ.

Удирдагч: Их Эзэн єршєєгєєрэй. Сїсэгтнїїд: **Их Эзэн єршєєгєєрэй.**

удирдагч: Христ єршєєгєєрэй Сїсэгтнїїд: **Христ єршєєгєєрэй.**

Удирдагч: Их Эзэн єршєєгєєрэй. Сїсэгтнїїд: **Их Эзэн єршєєгєєрэй.**

## АЛДАРШУУЛАЛ

Сїнсэнд чуулсан бид Аавд болон Хурганд залбирч бас магтан дуулдаг.

**Хамгийн дээд оргилд байгаа Бурхан алдаршиж, дэлхий дээрх Тїїний хїмїїс амар амгалан орштугай. Их Эзэн Бурхан тэнгэрлэг Хаан, агуу хїчирхэг Бурхан бас Эцэг, Танд бид сїсэглэн мєргєж, Танд бид баярлан талархаж, Таны алдарыг магтан дуулъя. Их Эзэн Есїс Христ, Эцэгийн цорын ганц Хїї, Их Эзэн Бурхан, Бурханы Хурга, та дэлхийн нїглийг зайлуулдаг: биднийг єршєє. Та Эцэгийн баруун гарт залардаг: бидний залбирлыг хїлээн аваач. Учир нь Эцэг Бурханы сїр жавхланд Ариун Сїнстэй ганц Та Ариун Нэгэн, ганц Та Их Эзэн, ганц Та эрхэм дээд, Есїс Христ билээ. Амэн.**

## НЭЭЛТИЙН ЗАЛБИРАЛ

Ёслолын удирдагч биднийг хэсэг мєч чимээгїй залбирхыг урьж, дараа нь Ариун Сїнсэн дэх Христийн бясалгалаар дамжуулан бидний нэрээр єдрийн ёслол ба Эцэг Бурханы айлтгалын сэдвийг илэрхийлдэг.

Бїгдээрэє залбирцгаая.

Тэгээд ёслолын удирдагч залбирлыг хэлэх юмуу дуулах бєгєєд тєгсгєлд нь сїсэгтнїїд хариулна:

**Амэн.**

# ЇГИЙН ТУНХАГЛАЛ

Бурханы Їгийн тунхаглал нь їргэлж тїїний Їгээр дамжин ирдэг Христийн тухай байдаг. Хуучин Гэрээний уншлагууд нь Христийн тухай зєгнєдєг бол Шинэ Гэрээний ном шууд Тїїний тухай єгїїлдэг. Бїх судрууд итгэх, дагахыг уриалдаг. Уншлагын дараа бид Бурханы їгийг эргэцїїлж, тэдгээрт хариулдаг.

## НЭГДЇГЭЭР УНШЛАГА

Уншигч нэгдїгээр уншлагыг уншихаар индэрт гарч ирнэ. Бїгд суугаад сонсоно.
Уншлагын дараа уншигч дууссаныг илэрхийлж **Энэ бол Их Эзэний їг** гэж хэлнэ: Бїгд хариуд нь: **Бурхандаа талархъя** гэж хэлнэ.

## ХАРИУ ДУУЛАЛ

Сїсэгтнїїд дуулалыг дуулах юмуу уншина.

## ХОЁРДУГААР УНШЛАГА

Хэрэв хоёрдугаар уншлага байгаа бол їїнийг нэгдїгээр уншлагын адилаар индэр дээрээс уншина. Уншигч мєн дууссанаа илэрхийлж **Энэ бол Их Эзэний їг** гэж хэлнэ. Бїгд хариуд нь: **Бурхандаа талархъя** гэж хэлнэ.

## АЛЭЛУЙЯА БА АЙЛДЛЫГ ТУНХАГЛАХ

Есїс айлдлаар бидэнтэй ярих болно. Бид хїндлэх їїднээс босож тїїний сургаалд талархалтайгаар бэлддэг.

## АЙЛДАЛ

Энэ завсар хэрэв хїж хэрэглэж байгаа бол лам бойпор дээр хїж нэмнэ. Тэгээд айлдлыг тунхаглагч дикон ёслолын удирдагчын ємнє мэхийн нам дуугаар адислалыг гуйна:

Аав аа, намайг адислаач.

Ёслолын удирдагч нам дуугаар хэлнэ:
Та Их Эзэний айлдлыг тунхаглах тул
Тэр Таны сэтгэл зїрхэнд байх болтугай.
Аав, Хїї, + Ариун Сїнсний нэрээр.

Дикон хариуд нь: Амэн.

Хэрэв дикон байхгїй бол ёслолын удирдагч тахилын ширээний ємнє бєхийн аяархан хэлнэ:

Агуу хїчирхэг Бурхан минь,
би Таны айлдлыг тунхаглах тул
Та миний зїрх сэтгэлийг ариусгаач.

Тэгээд дикон (эсвэл ёслолын удирдагч) индэрт гарна. Хїж лаа барьсан хїмїїс тїїнийг дагана. Ёслолын удирдагч хэлэх юмуу дуулна.

Их Эзэн та нартай хамт байх болтугай.

Сїсэгтнїїд:
**Таньтай ч бас хамт байх болтугай.**

Дикон (эсвэл ёслолын удирдагч) хэлэх юмуу дуулна.
... -ийн ариун айлдлаас хийх уншлага.
Ёслолын удирдагч эхлээд номыг загалмайлаад дараа нь дух, уруул, цээжиндээ загалмайлна.

Сїсэгтнїїд хариуд нь:
**Их Эзэн таныг алдаршуулъя.**

Айлдлын тєгсгєлд дикон (эсвэл ёслолын удирдагч) хэлнэ:

Энэ бол Их Эзэний айлдал.

Бїгд хариулна:
**Их Эзэн Есїс Христ таныг магтъя.**

Тэгээд дикон (эсвэл ёслолын удирдагч) номоо їнсэн нам дуугаар хэлнэ:

Айлдлын їгс бидний нїглийг ариусгах болтугай.

## НОМЛОЛ

Бурханы їгийг номлолоор дахин ярьдаг. Ариун Сїнс номлогчоор дамжуулан библийн уншлагыг сїсэгтнїїдийн тухайн їеийн хэрэгцээнд тохируулан тайлбарладаг. Тэр биднийг амьдралаараа Христэд хариулахыг уриалдаг.

## СЇСЭГ БИШРЭЛИЙН ЇГ

Судар болон номлол дахь Бурханы сургаалыг хїлээж авсхаа, мєн эртний Сїмээс їїсэлтэй шїтлэгийн їгийг тунхаглснаар итгэлээ илэрхийлдэг

**Бид цорын ганц Бурхан, Аав, Агуу хїчит, тэнгэр болон дэлхий ертєнц, харагдах болон їл харагдах бїгдийг Бїтээгчид итгэдэг. Бид Бурханы цорын ганц Хїї, Ааваасаа мєнхийн гаралтай, Бурханаас ирсэн Бурхан, Гэрлээс ирсэн Гэрэл, їнэн Бурханаас ирсэн їнэн Бурхан, бїтээгдээгїй, Аавтай гарал нэгтэй цорын ганц Их Эзэн Есїс Христэд итгэдэг. Тїїгээр бїх юмс бїтээгдсэн Хїмїїн бидний авралын тєлєє Тэр тэнгэрээс морилон ирсэн: Тэр Ариун Сїнсний хїчээр олдон, Цэвэр Ариун Мариагаас тєрж, хїн болсон. Бидний тєлєє тэр Понти Пилатын тушаалаар загалмайд цовдлогдон, зовж шаналан нас барж, булшлагдсан. Ариун Сударын биелэлээр гурав дахь єдєр Тэр дахин амилж; тэнгэрт залран. Аавын баруун гарт залагдсан. Алдар суугаа бадруулан амьд болон їхэгсэдийг шїїхээр дахин ирэхэд нь тїїний хаанчлал тєгсгєл їгїй болно. Бид Их Эзэн, амьдрал хайрлагч, Эцэг Хїїгээс ирэгч,**

**Ариун Сїнсэнд итгэдэг. Тэр Эцэг Хїї хоёрын хамт дээдлэгдэн алдаршдаг. Тэр зєнчдєєр дамжуулан ярьсан. Бид цорын ганц ариун бїх нийтийн, Шавь нар дээр тулгуурласан ариун Сїмийнхэнд итгэдэг. Нїглээс єршєєгдєхийн тулд бид цорын ганц ариуслын угаалгыг хїлээн авдаг. Бид їхэгсэдийн амилалт болон мєнхийн амьдрал ирэхийг хїсэн хїлээдэг. Амэн**

Хїїхдїїдтэй хамт тэмдэглэж буй мєргєлд дагалдагчдын шїтлэгийн їгийг номлолын дараа хэлж болно.

**Би агуу хїчирхэг Эцэг, Тэнгэр ертєнцийг бїтээгч Бурханд итгэдэг. Би Эцэгийн цорын ганц Хїї, бидний Их Эзэн, Есїс Христэд итгэдэг. Тэр Ариун Сїнсний хїчээр олдон, Цэвэр Ариун Мариагаас тєрсєн. Тэр Понти Пилатын тушаалаар загалмайд цовдлогдон, зовж шаналан нас барж, булшлагдсан. Тэр їхэл рїї доошилж, Тэр гурав дахь єдєр амилсан. Тэр дээш тэнгэрт залран, Эцэгийн баруун гар талд заларсан. Тэр амьд болон їхэгсэдийг шїїхээр Алдар суутайгаар дахин ирнэ. Би Ариун Сїнс, бїх нийтийн ариун Сїмийнхэн гэгээнтнїїдийн нэгдэл, нїглийн уучлал, махан биеийн амилалт, мєн мєнхийн амьдралд итгэдэг. Амэн.**

**НИЙТИЙН ЗАЛБИРАЛ**

Итгэгч бид Сїм болон дэлхийн єнєєгийн хэрэгцээний тєлєє залбирахаар бие биентэйгээ нэгддэг.

## МАГТААЛ, ТАЛАРХЛЫН ЗАЛБИРАЛ

Бурханы Їгийг бясалган бодсоноор бид Их Эзэний оройн зоог, ариун Талх Дарс Хуваалтын ёслол уруу ордог. Бид Их Эзэний Сїїлийн Зоогон дээрээ хийсэн їйлдлийг дурсан тэмдэглэдэг. Христийн аврагдсан ахан дїїс, Бурханы шинэ хїмїїс бид тїїний ширээг тойрон тїїний нэрийн дор цуглардаг. Энд бид Бурханыг ерєєж, бидний итгэл ба амьдралыг єєрчлєх Христийн бие ба цусан бэлэгийг хїлээн авахаар байж байна.

**МЄРГЄЛИЙН ШИРЭЭ БА ЄРГЄЛИЙН БЭЛТГЭЛ**

Магтаал Талархлын Залбирлын талх дарс болон Сїм ба ядуусын тєлєєх бидний бэлэгїїдийг мєргєлийн ширээн дээр авчирна. Их Эзэний мєргєлийн ширээ засагдаж байх зуур бид дуулах юмуу чимээгїй суун сэтгэл зїрхээ бэлтгэнэ. Дараа нь ёслолын удирдагч тавагтай талхыг аваад дээш єргєн зєєлнєєр хэлнэ:

Бїх ертєнцийн Бурхан, Их Эзэн Та ерєєлтэй. Таны єгєємєр сэтгэлийн ачаар газраас гарч хїний гараар бїтээгдсэн єргєлд єргєх талх бидэнд байна. Энэ нь бидний амьдралын талх болно.

Хэрэв єргєлийн дуу байхгїй бол ёслолын удирдагч чангаар ємнєх їгийг хэлнэ. Харин хїмїїс хариулна:

**Бурхан мєнхєд ерєєлтэй.**

Дикон (эсвэл ёслолын удирдагч) хундагыг дарсаар дїїргэн дусал ус нэмж аяархнаар хэлнэ:

Энэхїї ус дарсны нийлэлтээр бид Их Эзэн Христийн амьдралыг хуваалцаж, тїїнтэй нэгдэх болтугай.

Тэгээд ёслолын удирдагч дарстай хундагыг авч єргєєд аяархнаар хэлнэ:

Бїх ертєнцийн Бурхан, Их Эзэн Та ерєєлтэй. Таны єгєємєр сэтгэлийн ачаар модноос гарч хїний гараар бїтээгдсэн єргєлд єргєх дарс бидэнд байна. Энэ нь бидний сїсэг бишрэлийн цангааг тайлагч ариун ундаа болно.

Хэрэв єргєлийн дуу байхгїй бол ёслолын удирдагч чанга дуугаар ємнєх їгийг хэлнэ.

**Бурхан мєнхєд ерєєлтэй.**

Ёслолын удирдагч мэхийн аяархнаар хэлнэ:

Их Эзэн минь,бид Таниас биднийг хїлээн авч, даруу болон гэмшсэн сэтгэлээр єргєж буй бидний энэхїї єргєлийг таалаасай хэмээн гуйж байна.

Ёслолын удирдагч одоо тахилын ширээ болон өргөлийг хүжээр ариулна. Дараа нь дикон юмуу туслагч хүмүүсийг ариулна. Ингээд ёслолын удирдагч тахилын ширээний хажууд зогсон гараа угаан аяархнаар хэлнэ:

Их Эзэн минь, миний буруу явдлыг угааж, намайг нүглээс ариусгаж өгөөч.

Ёслолын удирдагч ширээний ард зогсоод сүсэгтнүүдийг харан гараа урагш сунган хавсраад хэлнэ:

Ахан дүүс ээ, агуу хүчирхэг Эцэг Бурхандаа бидний өргөлийг таалан аваасай хэмээн залбирцгаая.

Сүсэгтнүүд:

**Их Эзэн таны гар дээрх өргөлийг Өөрийн нэрийн алдар болон магтаал, бидний ба өөрийн Сүмийнхний сайн сайхны төлөө хүлээн авах болтугай.**

**ӨРГӨЛ ДЭЭРХ ЗАЛБИРАЛ**

Ёслолын удирдагч бидний төлөөнөөс эдгээр бэлгүүдийг хүлээн авч адислахыг Эцэгээс гуйдаг. Залбиралын төгсгөлд хүмүүс хариулна.

**Амэн.**

## МАГТААЛ, ТАЛАРХЛЫН ЗАЛБИРАЛ II

Бүхэл Ёслолын гол цөм, мөргөлийн үндсэн залбирал Магтаал Талархлын Залбирлын үйлчилгээг эхлэнэ. Ёслолын удирдагчын урилгаар бид Бурханд сэтгэл зүрхээ өргөж, Есүс Христээр дамжуулан Аавд хандсан түүний үгэнд нэгддэг. Бид Есүсийн ариун зоогыг дурсан тэмдэглэж, амьдралдаа түүнтэй хамт Бурханы гайхамшигт ажлыг хүлээн авснаар түүний тахилд нэгддэг. Ёслолын удирдагч Магтаал Талархлын Залбирлыг хэлж юмуу дуулж эхэлдэг.

Их Эзэн та нартай хамт
байх болтугай.

Сүсэгтнүүд:

**Тантай ч бас хамт байх болтугай.**

Ёслолын удирдагч үргэлжлүүлэн хэлнэ:

Сэтгэл зүрхээ Түүнд өргөцгөө.

Сүсэгтнүүд:

**Бид Их Эзэндээ түүнээ өргөцгөөе.**

Гараа сунгаастайгаар ёслолын удирдагч үргэлжлүүлэн:

Бидний Бурхан Их Эзэндээ талархцгаая.

Сүсэгтнүүд:

**Түүнд талархаж магтан дуулах нь зүйтэй.**

Ёслолын удирдагч тухайн Улирал юмуу онцгой Өдөрт зориулагдсан Оршилыг үргэлжлүүлэн хэлдэг.

[Аавыг Магтан дуулах]

Аав аа, Таны хайрт Хүү, Есүс Христээр дамжуулан хаана ч гэсэн Танд байнга талархаж байх нь бидний үүрэг ба аврал.

Есүс бол Үг, Түүгээр Та ертөнцийг бүтээсэн, мөн биднийг аврахаар илгээсэн Аврагч.
Ариун Сүнсний хүч чадлаар хүн биеийг олж, Цэвэр Ариун Мариагаас Тэр төрсөн.

Бидний төлөө загалмайд Тэр цовдлуулснаараа: үхэлд төгсгөл тавьж, дахин амилахыг нээсэн.
Үүгээр Тэр Таны хүслийг биелүүлж,
ариун хүмүүсийг Танд таалуулсан.

Иймд тэнгэрийн элчүүд болон гэгээн хүмүүстэй нэгдэн бид Таны алдрыг дуулан (хэлнэ)тунхаглана:

## МАГТУУ

Оршилын төгсгөлд хїмїїс ёслолын удирдагчын хамт магтууг дуулах юмуу чангаар хэлдэг:

**Ариун, ариун, ариун Их Эзэн агуу хїчирхэг Бурхан,**
**тэнгэр ертөнцөд Таны алдар нилдээ тїгжээ.**
**Хузана хамгаас өндөрт.**
**Их Эзэний нэрээр ирж ерөөгдсөн хїн тэр.**
**Хузана хамгаас өндөрт**

[Ариун Сїнсийг Дуудах]

Ёслолын удирдагч дуулах юмуу хэлнэ:
Их Эзэн, Та їнэхээр ариун,
Бїх ариуны ундрага.

Энэ өргөлийг ариусгахаар
өөрийн Сїнсээ тэдэн дээр ирїїлээч, тэгснээр тэр өргөлїїд бидэнд Их Эзэн Есїс Христийн бие + ба цус болоосой.

[Их Эзэний Оройн Зоог]

Тэр їхэлд өгөгдөхөөсөө өмнө
їхлийг чөлөөтэй хїлээж аваад, талх авч Танд талархсан. Тэр талх хувааж, шавь нартаа өгөөд хэлсэн нь:

**ТА НАР БЇГД ЇЇНИЙГ АВ,**
**ТЭГЭЭД ИД: ЭНЭ БОЛ ТА**
**НАРЫН ТӨЛӨӨ ЗОРИУЛАГДАХ**
**МИНИЙ БИЕ.**

Зоог дуусахад Тэр хундагатай дарс авсан. Дахин Тэр талархал магтаалыг Танд өргөн, хундагатай дарсыг шавь нартаа өгөөд хэлсэн нь:

**ТА НАР БЇГД ЇЇНИЙГ АВ, ТЭГЭЭД УУ: ЭНЭ БОЛ МИНИЙ ЦУСТАЙ ХУНДАГА, ЭНЭ ЦУС ШИНЭ БА МӨНХИЙН ГЭРЭЭНИЙ БАТАЛГАА.ЭНЭ ЦУСЫГ ТА НАР БОЛОН БЇХ ХЇН ТӨРӨЛХТНИЙ ТӨЛӨӨ УРСГАСАНААР ТА НАРЫН НЇГЭЛ АРИУСНА.**
**НАМАЙГ ДУРСАН ЇЇНИЙГ ХИЙ.**

[Дурсгалын Магтуу]

Ёслолын удирдагч дуулах юмуу хэлнэ:
Бїгдээрээ итгэл бишрэлээ илэрхийлцгээе.

Бїгдээрээ:

**А Христ нас барсан,**
**Христ дахин амилсан,**
**Христ эргэж ирнэ.**

**Б Їхлээрээ Та бидний їхлийг їгїйсгэсэн,**
**амилалтаараа Та бидний амьдралыг сэргээсэн.**
**Их Эзэн Есїс алдар хїндтэйгээр залраарай.**

**В Бид энэ талхнаас идэж, дарснаас уухдаа,**
**Их Эзэн Таныг алдар хїндтэйгээр ирэх хїртэл, їхлийг тань тунхаглаж байна.**

[Дурсгалын Залбирал]

Ёслолын удирдагч їргэлжлїїлэн:
Тїїний їхэл болон дахин амилсны дурсгалд, амьдралыг тэтгэгч талх болон аврагч дарстай хундагыг, Аав Тандаа бид өргөн барья. Таны хамт байж, Танд їйлчлэх эрхтэй болгосон; Танд бид талархаж байна.

[Ариун Сїнсний Гуйлт]

Христийн бие ба цуснаас хуваалцсан бид бїгд Ариун Сїнсний хїчээр хамтдаа нэгдэх болтугай.

[Гуйлт: Сїмийн төлөө]

Их Эзэн, энэ дэлхий дээрх өөрийн Сүмээ санаач; биднийг манай Пап ..., хамба лам ... болон бусад бүх лам нарын хамт хайр ивээлээр дүүрэн амьдруулаач.

[Нас баргасдын төлөө]

Нас барсан хүмүүсийн төлөөх мөргөлд дараахь залбирлыг нэмж хэлж болно:

Та энэ амьдралаас дуудсан ...-ыг эргэн санаач. Ариуслын Угаалгаар тэр Христтэй хамт нас барсан: Тэр түүнтэй хамт дахин амилах болтугай.

Дахин амилах итгэлтэйгээр амгалан нойрсч байгаа бидний ах эгч дүүсийг санаач; тэднийг болон бүх хагацан одогсодыг өөрийнхөө гэрэлд оруулаач;

[Гэгээнтнүүдтэй нэг Нэгдэлд]

Бид бүгдийг өршөөгөөч;Бидэнд Бурханы эх Цэвэр Ариун Мариа, үеийн үед хүслийг тань гүйцээж ирсэн шавь нар мөн бүх гэгээн хүмүүсийн хамтаар мөнхийн амьдрал хуваалцах тавилан хайрлаач. Тэдэнтэй нэгдэн, Таны Хүү, Есүс Христээр дамжуулан Таныг бид магтан дуулж, Таныг бид алдаршуулна.

[Төгсгөлийн Ерөөл]

Ёслолын удирдагч хундагатай дарс болон тавагтай талхыг авч, тэдгээрийг дээш өргөөд дуулах юмуу хэлнэ:

**Түүгээр,**
**Түүнтэй,**
**түүнд,**
**Ариун Сүнсний нэгдэлд, бүх алдар ба нэр хүнд Таных,**
**агуу хүчирхэг Эцэг,**
**мөнхөөс мөнхөд орштугай.**

Сүсэгтнүүд:

**Амэн.**

# НЭГДЛИЙН ЁСЛОЛ

Амилалтын баярын зоогонд бэлдэх, Их Эзэнийг угтан авахаар бид уучлал өршөөлийн төлөө залбирцгааж амар мэндээ солилцдог. Христийн биеийг идэж, цусыг уухаасаа өмнө бид Сүмд түүнтэй болон ахан дүүстэйгээ заавал нэг болсон байх ёстой.

## ИХ ЭЗЭНИЙ ЗАЛБИРАЛ

Ёслолын удирдагч дарстай хундага болон талхыг буулгаад алгаа хавсран дараахь залбирлуудаас дуулах юмуу хэлнэ:

**А** Бидний Аврагчийн үгээр Аавдаа итгэлтэйгээр залбирцгаая.

**Б** Есүс бидний Бурхан Аавыг хэрхэн дуудахыг заасан учир үүнийг бүгд зоригтойгоор хэлцгээе.

**В** Бидний нүглийг уучилж,
бидэнд дайснаа уучлах чадвар хайрлаач гэж Ааваас гуйцгаая.

**Г** Есүсийн бидэнд заасан хаанчлал ирээсэй гэж залбирцгаая.

Ёслолын удирдагч хүмүүстэй хамт үргэлжлүүлэн:

**Тэнгэр дэх Аав аа, Таны нэр ариун байх болтугай. Таны хаанчлал ирэх болтугай. Таны таалал тэнгэрт биелдэгийн адил дэлхийд ч биелээсэй.**
**Өнөөдөр бидэнд өдөр тутмын хэрэгцээт бүхнийг хайрлаач. Бидэнд нүгэл үйлдэгчдийг бид уучилд-гийн адил бидний нүглийг уучлаач. Биднийг нүгэл рүү оруулагч зүйл рүү битгий явуулаач. Харин биднийг муу бүхнээс аварч өгөөч.**

Ёслолын удирдагч үргэлжлүүлэн:

Их Эзэн минь, биднийг муу бүхнээс аварч, амар амгалангаа хайрлаач.
Бид Аврагч Есүс Христийн ирэхийг баярт найдвартайгаар хүлээж буйн учир өршөөлөөрөө биднийг нүглээс чөлөөлөн, аливаа зовлонгоос хамгаалаач.

Хїмїїс залбирлыг магтуугаар тєгсгєнє:

**Учир нь хаант улс, хїч чадал, алдар хїнд таных,**
**одоо бас їїрд мєнх.**

## АМАР АМГАЛАНГИЙН БЭЛГЭДЭЛ

Сїм бол хайранд Ариун Сїнсээр нэгдсэн Хрисчдийн нэгдэл юм. Их Эзэний нэг Биеийг идэж, авралын нэг Хундаганаас уухын ємнє тэд амар тайван нэгдлээ илэрхийлэх болон батжуулах, сэргээх хэрэгтэй. Бид їїнийг амар амгалангийн тэмдэгээр илэрхийлдэг.

Их Эзэн Есїс Христ Та шавь нартаа:
“Би та нарт амар амгалангаа їлдээе, єєрийн амар амгаланг та нарт єгье” хэмээн хэлсэн. Бидний нїглийг биш, харин єєрийн Сїмийнхний итгэлийг харж,, мєнхєд амьдардаг улсынхаа амар амгалан ба эв нэгдлийг хайрлан соёрхооч.

Сїсэгтнїїд:
**Амэн.**

Ёслолын удирдагч нэмж хэлнэ:
Их Эзэний амар амгалан їргэлж та нарт байх болтугай.

Сїсэгтнїїд:
**Танд ч бас байх болтугай.**

Тэгээд дикон (юмуу ёслолын удирдагч) нэмж хэлнэ:
Их Эзэний амар амгаланг бие биендээ илэрхийлцгээе.

Бїгд бие биентэйгээ гар барьж амар амгаланг хїснэ.

## ТАЛХ ХУВААЛТ

Хрисчид “талх хуваалт”-ын тєлєє цуглардаг бєгєєд энэ нь Мєргєлийн єєр нэг нэр юм. Бид хэдий олон боловч нэг талх болсон Христэд нэгэн бие болдог.

**Бурханы хурга, Та дэлхийн нїглийг зайлуулагч: биднийг єршєєгєєч.**
**Бурханы хурга, Та дэлхийн нїглийг зайлуулагч: биднийг єршєєгєєч.**
**Бурханы хурга, Та дэлхийн нїглийг зайлуулагч: бидэнд амар амгалангаа хайрлаач.**

## НЭГДЛИЙН ТЄЛЄЄХ БЭЛТГЭЛ

Ёслолын удирдагч дараахь залбирлыг хэлнэ:

Их Эзэн Есїс Христ, амьд Бурхан Хїї минь, Аавын хїсэл ба Ариун Сїнсний хїчээр, Таны їхэл дэлхийд амьдрал авчирсан. Ариун бие ба цусаараа биднийг нїгэл хилэнц хийгээд муу бїх-нээс ариусгаж єгєєч. Биднийг сургаалдаа їнэнч байлгаж, єє-рєєсєє хэзээ ч бїї салгаач.

Эсвэл:

Их Эзэн Есїс Христ, бид Таны хайр болон єршєєлд итгэлтэйгээр бие ба цуснаас тань хїртэж байна. Таны бие, цус бидэнд ял зэмлэл биш, харин бие, сэтгэлд маань эрїїл энх авчрах болтугай.

## АРИУН НЭГДЭЛ

Бид чимээгїй залбирч, дараа нь Талх Дарс хуваах ёслолд Христтэй уулзах бэлтгэл болгон найдварын їгсийг даруухнаар хэлдэг.

Энэ бол дэлхийн нїглийг зайлуулагч Бурханы хурга. Тїїний зоогонд уригдсан хїн бїр баяр жаргалтай.

Ёслолын удирдагч сїсэгтнїїд хамт хэлнэ:
**Их Эзэн би Таныг хїлээж авах зохистой нэгэн биш боловч, Таныг їгээ хэлбэл би эдгэрэх болно.**

Тэгээд ёслолын удирдагч талх идэхийн ємнє нам дуугаар хэлнэ:

Христийн бие намайг мєнхийн
амьдралд аваачих болтугай.

Тэгээд ёслолын удирдагч Їнэт Цусыг уухын ємнє хэлнэ:

Христийн цус намайг мєнхийн
амьдралд аваачих болтугай.

Ёслолын удирдагч сїсэгтнїїд рїї очиж хїн бїрт хандан хэлнэ:

Христийн бие.

Сїсэгтнїїд:

**Амэн.**

## НЭГДЛИЙН ДУУ

Христийн биеийг ёслолын удирдагч хїлээн авах їед нэгдлийн дуу эхлнэ. Нэгдлийн дараа ёслолын удирдагч юмуу дикон савыг цэвэрлэж байхдаа аяархнаар хэлнэ:

Их Эзэн минь, би эдгээр бэлгїїдийг цэвэр ариун зїрх сэтгэлээр хїлээн авах болтугай.
Эдгээр нь надад одоо бас їїрд эрїїл энх, хїч чадал авчирах болтугай.

## ЧИМЭЭГЇЙ ЗАЛБИРЛЫН БУЮУ МАГТАН ДУУЛАЛЫН ЇЕ

Тэгээд ёслолын дараа удирдагч суудалдаа эргэн сууна. Чимээгїй залбирах эсвэл дуулал буюу магтан дуулалыг дуулдаг.

## НЭГДЛИЙН ДАРААХЬ ЗАЛБИРАЛ

Христ бидэнд хїч тэнхээ єгсєн тул биднийг итгэлтэйгээр амьдраасай хэмээн ёслолын удирдагч бидний ємнєєс залбирдаг. Бидний Амэн гэсэн хариулт нь тїїний залбирлыг биднийх болгодог.

Бїгдээрээ залбирцгаая.

Ёслолын удирдагч Нэгдлийн Ёслолын дараа залбирал дуулах юмуу хэлэх бєгєєд тєгсгєлд нь сїсэгтнїїд хариу хэлнэ:

**Амэн.**

# ТЄГСГЄЛИЙН ЁСЛОЛ

Бид Бурханы Їгийг сонсож Христийн биенээс хуваалцсан. Тэгвэл одоо єдєр тутамын амьдралдаа Их Эзэнийг магтах, ерєєх, сайн зїйл хийхээр явах цаг боллоо.

## ЇДЭЛТ

Хаалтын ёслол. Ёслолын удирдагч хэлэх юмуу дуулна:

Их Эзэн та нартай хамт байх болтугай.

Сїсэгтнїїд:

**Тантай ч бас хамт байх болтугай.**

Ёслолын удирдагч дараахь їгийг хэлэн сїсэгтнїїдийг адислана:

Агуу хїчирхэг Бурхан, Аав, Хїї, + Ариун Сїнс та нарыг адислах бол-тугай.

Сїсэгтнїїд:

**Амэн.**

## ХААЛТ

Тєгсгєл нь сїсэгтнїїдийг Их Эзэнийг ерєєх, магтах болон сайн зїйл хийхийг уриалдаг.

Тэгээд дикон (юмуу ёслолын удирдагч) хэлнэ:

**А** Христийн амар амгаланд очицгоо.
**Б** Мєргєл єндєрлєлє, амар амгаланд очицгоо.
**В** Их Эзэнийг хайрлаж, Тїїнд їйлчлэхээр амар амгаланд очицгоо.

Сїсэгтнїїд:

**Бурхандаа баярлалаа.**

Ёслолын удирдагч тахилын ширээнд мєргєлийн эхнийх шиг мєргєнє. Тэгээд туслагчдын хамт хїндэтгэлтэйгээр ариун газрыг орхино.